

x1

## УСАН СПОРТ СУРГАЛТЫН ТӨВИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Усан спорт сургалтын төв нь 1986 онд МХЗЭ-ийн Төв Хорооны харьяа хүүхэд, залуучуудын усан спорт сургалтын БАССЕЙН нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

### *Нэг. Барилга байгууламж, техникийн хүчин чадал*

- Усанд сэлэх спортын улс, олон улсын уралдаан тэмцээн явуулах, стандартын шаардлага хангасан 240 хүний үзэгчдийн суудалтай, 3-5 метрийн өндөр үсрэлтийн 3 тавцан бүхий нэг ээлжиндээ 36-40 хүн хичээллэх, насанд хүрэгчдийн зургаан замтай усан сан. Хэмжээ нь 25x16x5 метр. Багтаамж нь 1200 шоо метр.
- Ээлжиндээ 16-20 хүүхэд хичээллэх 10x6x1 метрийн хэмжээтэй 60 шоо метр багтаамжтай жижиг усан сан.
- Сургалт дасгалжуулалт, спорт тоглоом, бэлтгэлийн зориулалттай 20x10 метрийн танхим, 12-20 хүний суудалтай цайны газар.
- Ус шинжилгээний лаборатори, эмнэлгийн хяналт, үзлэг сургалт-арга зүйн кабинетүүдтэй.
- Чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх зориулалтын нэг ээлжинд 3-6 хүнд үйлчлэх саун.
- Ус халаах, цэвэрлэх, ариутгах, шахах байгууламж, сантехник, дулаан, агааржуулалтын орчин үеийн техник тоног төхөөрөмжтэй.

### *Хоёр УССТөвийн үйл ажиллагааны зорилго*

Нийслэлийн хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, усан спортын төрлөөр хичээллэгчдийг сургах, ур чадварыг дээшлүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, усан спортын мэргэжлийн сургалт арга зүй- үйлчилгээний үйл ажиллагаа явуулна.

### *Гурав Эрүүл ахуйн ариун цэврийн нөхцөл*

Нийслэл, дүүргийн эрүүл мэндийн хяналтын албаны байнгын хяналтанд ажилладаг. Орчны ялангуяа усыг халдваргүйжүүлж ариутгах асуудлыг анхаарлын төвд байлгагдгаас УСТ - 900-92-ын шаардлагыг биелүүлж байна.

Ийнхүү стандартын шаардлага хангахын тулд 1987 онд батлагдсан " Эрүүлжүүлэх, спорт сургалтын усан бассейны түр дүрэм" -ийг үйл ажиллагаанд баримтлан ажилладаг.

3.1. Бассейны усыг байнгын эргэлтэнд байлгаж зориулалтын шахуургаар сэлгэдгээс гадна хоногт нийт усны 10.0 хувийг шинээр сэлбэж байна.

3.2. Усны механик шүүлтүүрийг жилд нэг удаа цэвэрлэж ашиглах ёстой. Сүүлийн жилүүдэд тунадасыг аваагүй байна. 2002 оны 07 дугаар сард бүх шүүлтүүрийг цэвэрлэсэн.

3.3. Усны температурыг өдөрт 4-өөс доошгүй удаа хэмждэг. Зөршөөрөгдөх температур 26 °С - 28°С байна. Ус дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- |                         |                          |
|-------------------------|--------------------------|
| - Булинггаралтын хэмжээ | 2мг/л -ээс ихгүй         |
| - Өнгө                  | 5° -аас ихгүй            |
| - Тунгалагжилт          | 30см-ээс ихгүй           |
| - Үнэр амт              | 3 баллаас ихгүй          |
| - Аммиак                | 0.05 мг/л -ээс ихгүй     |
| - Исэлдэх чанар         | 4 мг/л -ээс ихгүй байна. |

Эдгээр үзүүлэлтээр өдөр бүр лаборатори шалгаж байх учиртай. Одоогоор лаборатори ажиллаагүй. Үндсэн гурван багажны хангалт, урвалж бодисын нийлүүлтийг хийсэн. Хичээлийн шинэ жилээс дэрээх үзлэгийг өдөр бүр хийнэ. Одоогийн нөхцөлд нийслэлийн эрүүл мэндийн хяналтын албанаас сард шалгалт хийгдэж үндсэн үзүүлэлтүүдийг шаардлага хангаж байгааг мэдээлж байдаг.

3.4. Усыг цэвэр байлгах үндсэн арга нь хлорын цэвэрлэгээ байна. Үлдэгдэл хлорыг доод тал нь 2 удаа түүнээс дээш үзэж нягталдаг.

3.5. Харьцангуй чийгшил 60.0-70.0 хувь байх ёстой. Салхижуулалтын системийн доголдлоос энэ үзүүлэлт хүйтний улиралд 85.0 хувиас доош байх нь ховор байв. Засвараар салхижуулалт хэвийн болно.

3.6. Бассейнд ариун цэврийн өдрийг сард нэг удаа зохион байгуулж ариутгал, халдваргүйжүүлэлтийг 5.0 хувийн хлорамины болон одоо өргөн хэрэглэгдэх болсон ариутгалын бодисуудаар угаалга цэвэрлэгээний ажлыг хийж байна.

3.7. Бассейны усны ариутгалд кварцын гэрлийг шөнийн цагт асааж хэрэглэдэг. Мөн хана туурганы хэсгийг кварцын гэрлээр шарах ажлыг байнга хийж байна.

3.8. Бассейнд хичээллэгчид, чөлөөт сэлэгчдийн хувийн ариун цэврийг сахиулахад анхаардаг. Хичээллэгчид эмчийн үзлэгт орж зөршөөрөл авдаг уламжлалтай. Чөлөөт сэлэгчдийн хувьд энэ шаардлага тавигдаггүй. Зөвхөн өөрийн эмч нарын ил үзлэгээр шалгагдан нэвтэрдэг.

*Дөрөв Стратегийн зорилтууд*

1. Хүн амын чөлөөт цагаа өнгөрөөх таатай орчин бий болгох
  - Гадна орчныг тохижуулж худалдаа үйлчилгээ бүхий амралтын бүс болгоно
  - Барилгын өрөө тасалгааны ашиглалтыг сайжруулж усан болон комьюторын тоглоомын өрөөтэй болно.
2. Үйчилгээ болон сургалтын чанарыг сайжруулж, нэр төрлийг нэмэгдүүлэх
  - Сургалтын тодорхой хөтөлбөрүүд боловсруулж батлгаажуулна
  - Сургалтын материал тоног төхөөрөмж хэрэгслээр хангана.
  - Багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлж мэргэшүүлнэ
3. Усан спортыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
  - Усан спортын бусад холбоод, клубуудтай гэрээний үндсэн дээр хамтран ажиллана.
  - Биеийн тамирын багш бэлтгэдэг их, дээд сургуулиудтай хамтран усан спортын багш дасгалжуулагчдыг бэлтгэхийн зэрэгцээ усан спортын сургалтыг голлосон ерөнхий бодловсролын сургалтыг дэмжиж хамтарна.
  - Сэлж сурахыг хүсэгчид, чөлөөт цагаа усан сэлэлтээр өнгөрөөгчид, эмчилгээний болон сургалтын тусгай хөтөлбөрөөр хичээллэгсэд, усан спортын тамирчдыг өргөнөөр хамруулна.

*Тав Ойрын зорилтууд*

1. Бүтэц зохион байгуулалтын хувьд
  - Чадварлаг, мэргэшсэн багш-дасгалжуулагчдыг сонгон ажиллуулна.
  - Төрийн үйлчилгээний болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргана.
  - Хичээллэгчид, тамирчид багш-дасгалжуулагчаа сонгон хичээллэх боломж бүрдүүлнэ.
  - Тамирчдын хичээл сургалтыг спорт клубын чиглэлээр явуулна.
2. Санхүү эдийн засгийн хувьд

- Санхүүгийн бүртгэл хяналтыг эрс сайжруулж менежментийг бизнесийн зөв ойлголттой болгон
- Төсвийн татаасыг багасгахын хамт ажиллагсадыг нийгмийн асуудлыг дэс дараатай шийдвэрлэнэ.

Манай хаяг: Монгол Улс Улаанбаатар-210648  
Залуучуудын өргөн чөлөө  
Усан спорт сургалтын төв  
Утас : 325569, 325386, 318180

Усан Спорт Сургалтын Төв

## МАНАЙ ХАМТ ОЛОН

Бид энэ байгуулагадаа 1-12 жил ажилласан хөдөлмөрийн хамт олон.

Хамгийн олон жил ажилласан нь анхны захирал, усан спортын загалмайсан эцэг Довдонгийн БАЯРАА болно.

Тэрээр 1986.12.31-нд бассейныг хүлээн авсан анхны монгол мэргэжилтэн юм. 1986-1998 онуудад захирлаар, 2002 оноос багш дасгалжуулагчаар ажиллаж байна.

### Бидний боловсрол мэргэжлийн байдал

ДЭЭД 12	Багш 4, эмч 2, инженер 3, малынэмч 1, санхүүч 1, химич 1
ДУНД 16	Жолооч 4, барилгачин 2, сувилагч 1, цахилгаанчин 1, сантехникч 3, бусад 5
БАГА 2	Оёдолчин 1, нэхмэлчин 1 тус тус байна.

### Хөдөлмөрийн үнэлгээ мэргэжсэн байдал

1. Монгол Улсын Төрийн соёрхолт лаборант Бадрахын ДЭНСМАА
2. Алтан гадас одонт Захирал Шаравдоржийн ДӨРВӨНЖИН
3. Монгол улсад биеийн тамирын байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойн медальт багш дасгалжуулагч Довдонгийн БАЯРАА
4. Хан-уул дүүргийн цагдаагийн хэлтсийн ажил мэргэжлийн хошой аварга сэргийлэгч жижүүр Доржхоролын ПҮРЭВСҮРЭН
5. Завхан аймгийн 1984,1991 оны хөдөлмөрийн аварга жижүүр Загдын МАГВАН
6. Монголын залуучуудын холбооны алтан медальт, Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн 3 удаагийн аварга нярав-жолооч Дорлигжавын ЭРДЭНЭПИЛ
7. Оросын холбооны улсын усанд сэлэлтийн I зэрэгтэй ахлах багш дасгалжуулагч Нордодын БАЯРСАЙХАН
8. Монголын анхны халхын зайн сэлэгчийн лэг. Архангай аймгийн Тэрхийн цагаан нуурыг уртаан сэлж гаталсан багш Зэнээгийн ЗОРИГТ

### Ажилласан хугацааны байдал

УССТӨвд		Улсад	
1-2 жил	23	1-2 жил	9
2-5 жил	6	2-5 жил	6
5-10 жил	-	5-10 жил	2
10-15 жил	1	10-15 жил	1
15 жилээс дээш	-	15 жилээс дээш	10

### Ажиллагсадын насны бүтэц

20-25	2
25-30	18
35-40	2
45-50	4
50-55	1
55-аас дээш	3

УССТӨв

2003 он

### Усан спорт сургалтын төвийн товч түүх

2008 он.

Улаанбаатар хотын орчинд 1966 онд усны их үер болж маш их гай гамшиг учруулсан билээ. Үүнээс үүдэн Монголд усан спортын төрлийг хөгжүүлэх шаардлагтай болсон юм. Усан спорт сургалтын төв нь 1986 онд МХЗЭ-ийн Төв Хорооны харьяа хүүхэд, залуучуудын усан спорт сургалтын Бассейн нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Үүнээс хойш 20 жилийн хугацаанд тус төвийн өөрчлөн зохион байгуулагдсан он сар өдөр:

1. 1987.01.01-1991.03.21 - МХЗЭ-ийн төв хорооны харьяанд

2. 1991.03.21-1994.02.25 –Залуучууд спортын хороонд /Засгийн газрын 1991 оны 96 тоот тогтоолоор

3. 1994.02.25-1996.10.12 – Залуучуудын газрын харьяанд /ХАБХЯ-ны сайдын 1994 оны 24 тоот тушаалаар

4. 1996.10.12-1997.02.14 Залуучууд гэр бүл ,эмэгтэйчүүдийн газрын харьяанд /ЭМНХЯ-ны сайдын 1996 оны А/247 тоот тушаал /

5. 1997.02.14 Татан буугдаж Залуус төвтэй нэгдэн “Залуучуудын ордон “ҮҮГ болон бүтцийн өөрчлөлт хийгдсэн / Төрийн өмчийн хорооны 1997 оны 34 тоот тогтоолоор/

6. 2005 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2005 оны 09.16-ний өдрийн 371 тоот захирамжаар УССТөв нь Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар болсон.

Байгуулагдсан цагаас эхлэн захирлаар ажиллаж байсан хүмүүс:

1. Довдонгийн Баяраа 1986-1997

2. Долшоржав Ганцагаан 1997-1998

3. Намсрайжав Болдбаатар 1998-1999

4. Дамбын Ганбат 1999-2001

5. Шаравдорж Дөрвөнжин 2001-2006

6. Ёндонгийн Ганбат 2006 .08.31 –нээс тус төвийн захирлаар ажиллаж байна.

Нэг. Барилга байгууламж, техникийн хүчин чадал.

-Усанд сэлэх спортын улс, олон улсын уралдаан тэмцээн явуулах, стандартын шаардлага хангасан 240 хүний үзэгчдийн суудалтай, 3-5 метрийн өндөр үсрэлтийн 3 тавцан бүхий нэг ээлжиндээ 36-40 хүн хичээллэх, насанд хүрэгчдийн зургаан замтай усан сан. Хэмжээ нь 25x16x5 метр. Багтаамж нь 1200 шоо метр.

-Ээлжиндээ 16-20 хүүхэд хичээллэх 10x6x1 метрийн хэмжээтэй 60 шоо метр багтаамжтай жижиг усан сан.

-Сургалт дасгалжуулалт, спорт тоглоом, бэлтгэлийн зориулалттай 20x10 метрийн танхим, 12-20 хүний суудалтай цайны газар

-Ус шинжилгээний лаборатори, эмнэлгийн хяналт, үзлэг сургалт-арга зүйн кабинетүүдтэй

-Чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх зориулалтын нэг ээлжинд 3-6 хүнд үйлчлэх саунтай

-Ус халаах, цэвэрлэх, ариутгах, шахах байгууламж, сантехник, дулаан, агааржуулалтын орчин үеийн техник тоног төхөөрөмжтэй.

Хоёр. УССТөвийн үйл ажиллагааны зорилго.

Нийслэлийн хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, усан спортын төрлөөр хичээллэгчдийг сургах, ур чадварыг дээшлүүлэх, ирэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, усан спортын мэргэжлийн сургалт-арга зүйн-үйлчилгээний үйл ажиллагаа явуулахад оршино.

Гурав. Эрүүл ахуйн ариун цэврийн нөхцөл.

Нийслэл, дүүргийн эрүүл мэндийн хяналтын албаны байнгын хяналтанд ажилладаг. Орчны, ялангуяа усыг халдваргүйжүүлэх, ариутгах асуудлыг анхаарлын төвд

байдагаас УСТ-900-92 стандартын шаардлагыг биелүүлж байна.

Ийнхүү стандартын шаардлага хангахын тулд 1987 онд батлагдсан "Эрүүлжүүлэх, спорт сургалтын усан бассейны түр дүрэм"-ийг үйл ажиллагаандаа баримтлан ажилладаг.

3.1 Бассейны усыг байнгын эргэлтэнд байлгаж зориулалтын шахуургаар сэлгэдэгээс гадна хоногт нийт усны 20-30%-ийг шинээр сэлбэж байна.

3.2 Усны механик шүүлтүүрийг жилд нэг удаа цэвэрлэж ашиглах ёстой.

3.3 Усны температурыг өдөрт 4-өөс доошгүй удаа хэмждэг. Зөвшөөрөгдөх температур  $26^{\circ}$ - $28^{\circ}$  градус байна. Ус дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

-Булингаралтын хэмжээ	2мг/л-ээс ихгүй
-Өнгө	5 градусаас ихгүй
-Тунгалагжилт	30см-ээс ихгүй
-Үнэр амт	3 баллаас ихгүй
-Аммиак	0.05мг/л-ээс ихгүй
Исэлдэх чанар	4мг/л-ээс ихгүй байна.

Эдгээр үзүүлэлтээр өдөр бүр лаборатори шалгаж баталгаажуулдаг.

3.4 Усыг цэвэр байлгах үндсэн арга нь хлороор ариутгаж цэвэрлэх явдал юм. байна. Үлдэгдэл хлорыг доод тал нь өглөө орой 2 удаа түүнээс дээш үзэж нягталдаг.

3.5 Харьцангуй чийгшил 60.0-70.0 хувь байх ёстой. Сахижуулалтын системийн доголдлоос энэ үзүүлэлт хүйтний улиралд 85.0 хувиас доошгүй байдаг.

3.6 Бассейнд ариун цэврийн өдрийг сард нэг удаа зохион байгуулж ариутгал, халдваргүйжүүлэлтийг 5.0 хувийн хлорамины болон одоо өргөн хэрэглэгдэх болсон ариутгалын бодисуудаар угаалга цэвэрлэгээний ажлыг хийж байна.

3.7 Бассейны усны болон орчны ариутгалд кварцын гэрлийг шөнийн цагт асааж хэрэглэдэг. Мөн хана туурганы хэсгийг кварцын гэрлээр шарах ажлыг байнга хийж байна.

3.8 Бассейнд хичээллэгчид, чөлөөт сэлэгчдийн хувийн ариун цэврийг сахиулахад анхаардаг. Хичээллэгчид эмчийн үзлэгт орж зөвшөөрөл авдаг ба чөлөөт сэлэгчдийн хувьд энэ шаардлага тавигддаггүй. Зөвхөн өөрийн эмчийн биеийн гадна үзлэгээр шалгагдан нэвтэрдэг болно. асуудлыг дэс дараатай шийдвэрлэнэ.

### **Дөрөв. Сургалт үйлчилгээний талаар.**

2006-2007 оны сургуулийн хичээлийн жилээс эхлэн сургалтын программ, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан иргэд, аж ахуй нэгж байгууллагуудыг хүссэн цагтаа дуртай сургалтандаа суралцахаар зохион байгуулснаар иргэдийн талархлыг зарим нэгэн байдлаар хүлээж байгаа юм.

Сургалтын төлөвлөгөөг шинэчлэн багш нараар хичээлийн конспект гаргуулан, хичээллэгчдийн самбарыг том бассейнд байрлуулан хүн нэг бүртэй тулж ажиллан, даалгаврыг гар картаар өгч сургалт явуулж, хичээлийн журналыг бүрэн хэмжээгээр хөтлүүлж, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн төлөө чармайн ажиллаж байна.

Сургалтын төв нь 2006-2007 оны сургуулийн хичээлийн жилд шинээр дараах сургалтын үйл ажиллагааг явуулж байгаа болно. Үүнд:

- Усанд сэлэлтийн анхан шатны сургалт 16 цаг
- Усанд сэлэлтийн дунд шатны өврөөр сэлэх сургалт 16 цаг
- Усанд сэлэлтийн дунд шатны араар сэлэх сургалт 16 цаг
- Усан сэлэлтийн дээд шатны дельфин сэлэлтийн сургалт 24 цаг
- Усны аэробик
- VIP өрөө
- Фитнесс төв /бодибилдинг, аэробик/

- 24
- Гоо сайхан
  - Эмчилгээний массаж
  - Сауна
  - Саажилттай хүүхдийг усанд чийрэгжүүлэх, сэлж сургах сургалт 12 цаг
  - Усчин-аврагч бэлтгэх сургалт 48 цаг
  - Түргэвчилсэн усанд сэлэлтийн сургалт 8 цаг
  - Эрүүлжүүлэх эмчилгээний усанд сэлэлт
  - Эмчилгээ чийрэгжүүлэлтийн биеийн тамир
  - Тураах эрүүлжүүлэх сэлэлт зэрэг болно.

Ням гариг бүр өглөөний 8.45—аас оройны 21.15 хүртэл нийслэлийн иргэдэд чөлөөт цагийн сэлэлт зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Даваагаас Бямба гаригийг дуустал өдөр бүр өглөө 08.00 цагаас оройн 21.15 цаг хүртэл усанд сэлэлтийн бүх шатны сургалтуудыг явуулж байна.

### **Тав.Хөмрөгийн түүх**

Тус төв нь 1986 оноос 2001 оны архивт холбогдох материалыг цэгцлэн Төвийн захирлын тушаал тусгай жагсаалтаар 515 тушаалын хуудас 594 хуудас товъёогийн хамт 623 хуудас бүхий материалыг Нийслэлийн архивт шилжүүлсэн байна.

Бидэнд хадгалагдан дамжиж ирсэн материалууд лотор 1995,1996,1997.эдгээр гурван оны материал огт байхгүй .  
Бусад материлыг эмхлэн хөмрөг үүсгэсэн .Үүнд:

1. Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл :  
1986-2007 оны хоорондхи 32 дугаар бүхий /32/ гучин хоёр хадгалмжийн нэгж бүртгэгдсэн
- 2.Түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл

1998-2005 оны 76 дугаар бүхий /76/ далан зургаан хадгаламжийн нэгж бүртгэгдсэн

3.70 жил хадгалах хадгаламжийн нэгж :

1986-2006 оны 17 дугаар бүхий /17/ арван долоон хадгаламжийн нэгж бүртгэлтэй байна.

Устгах хэргийн акт:

Тус сургалтын төвийн захирлын 2008 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 23 тоот тушаалаар байгуулагдсан ББНШК-ыг байгуулан 2008 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 01 дүгээр хурлаар тус сургалтын төвийн 1986-2003 оны хадгалах хугацаа дууссан ,түүх эрдэм шинжилгээний болон практик ач холбогдолгүй болсон нийт 49 хэргийг устгасан болно.

Түүхчилсэн лавлах бичсэн:

УССТөвийн хүний нөөц ,сургалтын албаны дарга

*Ц.Алтанцэцэг*

/Ц.Алтанцэцэг /